



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Энхтайван найрамдлын ордон, Энхтайваны өргөн чөлөө,
3 дугаар хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас: 26 01 82

2024.12.02 № 01/2087
танай _____-ны № _____-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАРТ**

Тус газраас Монгол Улсын Хөгжлийн 2024 оны
төлөвлөгөөний хэрэгжилтийг хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *П. Алтанцэцэг* П.АЛТАНЦЭЦЭГ



1524 161055
ХААР: ХЯНГАН: БОЛ: 1524 161055

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин 2024	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО: ХҮНИЙ ХӨГЖИЛ БҮЛГИЙН ХҮРЭЭНД:					
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА					
3.3.1. Дотоодод худалдаалж байгаа эмийн чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ.	АХ-2.2.24, МУХТЖҮЧ-2.2.7 ЗГҮАХ-2.1.8	3.3.1.1.Эмийн нийлүүлэлт, худалдан оновчтой байгуулж, эмийн чанарыг сайжруулах	Арга хэмжээний хэрэгжилт	100	Эмийн нийлүүлэлт, худалдан авалтыг оновчтой зохион байгуулах ажлын хүрээнд: 1. "Хүүхдийн хорт хавдрын эмийн хангамжийг сайжруулах дэлхийн платформ" санаачлагыг хэрэгжүүлэх төслийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд: - Тус төслийн хүрээнд нийлүүлэгдэж буй эмийг хүлээн авахтай холбоотойгоор хил дээрх зохицуулалтад оролцогч талуудын уулзалт, эм хүлээн авагч ЭХЭМҮТ, ЗӨСҮТ-ийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан. - Хүүхдийн хорт хавдрын тусламж, үйлчилгээнд шаардлагатай 30 гаруй нэр төрлийн эмийг 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр ДЭМБ-аас ЭМЯ, ЭХЭМҮТ-д хүлээлгэн өгсөн. - Эмийн хадгалалт, түгээлтийн суурь стандартуудыг боловсруулахаар "Эс хордуулах эмийн зааврыг ДЭМБ болон бусад улс орны гарын авлага"-ыг орчуулж, стандарт ажлын заавар боловсруулж, 6 сарын 13-ны өдөр төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын эмийн 40 мэргэжилтнүүдэд танилцуулах сургалтыг зохион байгуулсан. - ДЭМБ, Сэйт Жүүд хүүхдийн хавдарын эмнэлгийн төлөөлөгчидтэй хамтран оролцогч талуудад 10 дугаар сарын 01-04-ний өдрүүдэд эм, эмнэлгийн хэрэгслийн төв агуулах болон хилийн боомт дээрх эм хадгалалтын процессийн танилцуулга, "Бараа материалын удирдлагын загвар стандарт" үйл ажиллагааны САЗ болон тэдгээрийг тухайн улсын нөхцөл байдалд тохируулан авч үзэх практик

Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин 2024	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
					сургалт, эмнэлзүйн САЗ-ын семинар болон улс орны нөхцөл байдалд зохицуулах практик сургалт зохион байгуулж, эм хүлээн авах 2023-2027 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан. 2. Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 42 дугаар тогтоолоор батлагдсан журмын хүрээнд Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх 99 нэр төрлийн эм, эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх 225 нэрийн эм нийт 324 нэрийн эмийн үнийн санал авах хүсэлтийг НҮБ-ын Хүүхдийн санд 3 дугаар сарын 22-ны өдөр хүргүүлсэн. Үнийн санал авах жагсаалтад багтсан 51 нэрийн эмийн тунг өөрчлөх, захиалгын тоо хэмжээг дахин баталгаажуулах саналыг НҮБ-ын Хүүхдийн сангаас 5 дугаар сарын 07-ны өдөр цахим шуудангаар мэдэгдсэн. Саналын дагуу төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 01/750, 01/751 дугаар албан бичиг тус тус хүргүүлж, санал авч, нэгтгэн 5 дугаар сарын 16-ны өдөр цахим шуудангаар НҮБ-ын Хүүхдийн санд хүргүүлсэн. НҮБ-ын Хүүхдийн сангаас цахим каталогит үнэ байршсан 58 нэрийн эмийн үнийн саналыг 6 дугаар сарын нэгдүгээр 7 хоногт ирүүлэх ба бусад нэрийн эмийн тендерийн үйл ажиллагаа явагдаж байгаа тухай мэдээллийг 6 дугаар сарын 04-ний өдөр ирүүлсэн. 3. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг олон улсын байгууллага болон гадаад улсын үйлдвэрлэгч, ДЭМБ-аас эмийн зохицуулалт, хяналтыг өндөр түвшинд гүйцэтгэдэг улсаас шууд болон дамжуулан худалдан авах зохицуулалтын хүрээнд эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох 18 нэр төрлийн эмийг худалдан авахаар үнийн хэлцэл хийсэн.

Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилгот түвшин 2024	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
					Үүний дагуу БНСУ-ын "DONGKOO BIO & PHARM" эмийн үйлдвэртэй ЭМЯ болон ЭЭХХЗГ хамтын ажиллагааны гэрээ байгуулж, 5 нэрийн эмийг нэг эх үүсвэрээс худалдан авалтыг хийж байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 47.5 дахь хэсгийг үндэслэн НЗҮ-ийн аргаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Dongkoo Bio Pharma үйлдвэрээс худалдан авах 5 нэрийн эмийн дотоодын Ложиستيкийн үйлчилгээ авах тендерийг 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр зарласан бөгөөд, тус тендерт Азифарма ХХК шалгарсан. 4. Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад ашиглах тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн төсөлд тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн төслийн тендерийг үнэлэх үндсэн шалгуур, шалгуур үзүүлэлтэд боловсруулж, ЭМЯ-нд 01/1424 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 5. Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрт 18 нэрийн эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрөл нэмэгдүүлэх хүсэлтийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт 01/2043 дугаар бичгээр хүргүүлсэн. 6. Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгддэг цахим дэлгүүрт байршсан 13 нэрийн эмэнд үнийн тохируулга хийх саналыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01/103 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн. Эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, сайжруулах чиглэлээр ЭМЯ-ны СХГ-ын даргын баталсан 10-00/19, 10-00/11, 03-01/01 дугаартай төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд 378 байгууллагад хяналт шалгалт хийж, 2020 заалттай 213 албан шаардлага, 3 иргэн, 27 ААН-д 17.8 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч 2,2 сая төгрөгийн хууль бус орлого нөхөн төлүүлсэн байна. Мөн ЭМЯ-ны СХГ-ын даргын баталсан 10-00/23, ЭЭХХЗГ-ын ЧХГ-ын даргын баталсан 07/08, 07/09 дугаартай удирдамж, ЦЕГ-ын ХТТГ-тай хамтран баталсан хяналт шалгалтын удирдамж,

Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин 2024	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
					төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд 371 аж ахуйн нэгжийг хяналт шалгалтад хамруулж, 31 заалттай 9 албан шаардлага, бүтээгдэхүүний дүгнэлт долоог үйлдэн 17 иргэн, 19 аж ахуйн нэгжид 27.2 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч 36.9 сая төгрөгийн хууль бусаар олсон мөнгө орлогыг нөхөн төлүүлж, 21 нэрийн 2332 ширхэг зөрчилтэй бүтээгдэхүүнийг хураан орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн байна.

—oOo—